



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/375

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд 2024 оны 07 дугаар сарын 11-ний өдөр орсон борооны улмаас аж ахуйн нэгжүүдэд учирсан хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх, хашаанд орсон шавар /лаг/-ыг зайлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Л.Батжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий санхүүч)

Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Н.Буян-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)

С. Анхбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын ахмад, гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч)

Б.Цэнддэлгэр (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Ганзориг (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

2. Хохирлын үнэлгээг тогтоож, лаг шаврыг зайлуулах ажлыг шуурхай зохион байгуулж, халдваргүйжүүлэх ажлыг хийлгэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011119

Захирамж2024